148

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 08 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагыг
магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг нэгдүгээр, нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг хоёрдугаар, сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг гуравдугаар, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг дөрөвдүгээр, өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг тавдугаар, сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Шалгуур үзүүлэлт батлах тухай" 395 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.УДВАЛ

080010

217

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 01 сарын 08 өдрийн
07 тоот тушаалын 6 дугаар
хавсралт

СУВИЛЛЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

А. Сувиллын цогцолбор, сувиллын газрыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	
			Байгууллага	Шинжээч
БҮЛЭГ 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт				
1.	Байгууллагын удирдлага, манлайлал	1.1 Бүтэц зохион байгуулалт нь тусгай зөвшөөрөлд заагдсан үйлчилгээний чиглэлээр зохион байгуулагдсан байх		
		1.2 Эрүүл мэндийн ажилтнууд орон тоогоор бүрэн ажилладаг байх		
		1.3 Сувилал нь шаардлагатай стандарт, удирдамж, эрх зүйн баримт бичгээр эрүүл мэндийн ажилтнуудыг хангасан байх		
		1.4 Байгууллага нь судалгаа, харьцуулсан үнэлгээнүүдэд үндэслэсэн стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй байх		
		1.5 Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ өгдөг, урамшуулал, хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байх		
		1.6 Ажлын байрны тодорхойлолтыг ажилтан бүрээр гарган баталгаажуулж, ажилтнуудыг байршуулсан байх		
		1.7 Дотоод хяналтын нэгж, ажилтан ажиллуулж, хяналтыг тогтмолжуулсан байх		
		1.8 Удирдлагын зөвлөл, багтай, байгууллагын тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэдэг байх		
		1.9 Ёс зүйн салбар хороотой, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх		
		1.10 Санхүүгийн хяналт,шалгалтад хамрагдсан,зөрчилгүй ажилласан байх		
		1.11 Настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ээлтэй орчинг бүрдүүлсэн байх		
2.	Хүний нөөцийн хөгжил	2.1 Хүний нөөцийн чадавхид жил бүр үнэлгээ өгч, түүнд үндэслэсэн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, /төлөвлөгөө/-тэй байх		
		2.2 Эмнэлгийн мэргэжилтнүүд нь бүгд эмчлэх, сувилах,эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх		
		2.3 Мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлсэн байх		

		2.4 Шинээр ажиллуулах эмнэлгийн Мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулалтаар авдаг байх	
		2.5 Эрүүл мэндийн ажилтнууд ёс зүйн сургалтад хамрагдсан байх	
		2.6 Шинэ ажилтанг сургаж, дадлагажуулдаг байх	
		2.7 Тасралтгүй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй, сургалтыг зохион байгуулсан байх	
		2.8 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байх	
3.	Тусламж үйлчилгээний чанарын удирдлага	3.1 Тогтмол ажиллагаатай чанарын алба, багтай, төлөвлөгөөтэй байх	
		3.2 Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг зохион байгуулж, ахиц гарсан байх	
		3.3 Эрүүл мэндийн ажилтнууд чанарын сургалтад хамрагдсан байх	
		3.4 Чанар сайжруулах дэвшилтэт аргуудыг нэвтрүүлсэн, үр дүнг тооцсон байх	
		3.5 Байгууллага нь чанарын үзүүлэлтийг баталж мөрдүүлсэн, түүнд нь ахиц гарсан байх	
		3.6 Байгууллага нь ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.7 Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.8 Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх	
4.	Мэдээллийн удирдлага	4.1 Байгууллага нь үйл ажиллагааны үзүүлэлтүүд болон хүний нөөц, санхүү, багаж тоног төхөөрөмж, эмийн мэдээллээр сүүлийн 5 жилээс доошгүй хугацааны мэдээний санг үүсгэж, тогтмол баяжуулдаг байх	
		4.2 Байгууллага нь гадаад, дотоод сүлжээнд холбогдсон, үйл ажиллагаа нь тогтмолжсон, эмнэлгийн мэргэжилтнүүд мэдээллийн сүлжээг ашигладаг байх	
		4.3 Цахим мэдээллийн нууцыг хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	
		4.4 Статистик, бүртгэл мэдээллийг журмын дагуу тайлагнадаг байх	
5.	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлага	5.1 Аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын багтай, төлөвлөгөөтэй ажилладаг байх	
		5.2 Байгууллага нь аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг тогтмол хийдэг байх	
		5.3 Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх	
		5.4 Эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьдаг байх	
6.	Байгууллагын соёл	6.1 Байгууллага нь үйлчилгээний соёлыг төлөвшүүлсэн байх	

		6.2 Урлаг, соёлын арга хэмжээ явуулах нөхцөл хангагдсан байх	
		6.3 Сувилал нь маркетингийн төлөвлөгөөтэй, үйл ажиллагаагаа сурталчилдаг байх	
7.	Байгууллагын ил тод байдал	7.1 Төсөв санхүүгийн, хүний нөөцийн, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилладаг байх	
БҮЛЭГ 2. Тусламж, үйлчилгээний технологийн мөрдөлт			
8.	Байгалийн нөөц ашиглалт	8.1 Рашааны ордыг ашиглах зөвшөөрөлтэй 8.2 байх	
		8.3 Рашааныг ашиглах гэрээтэй байх	
		8.4 Рашаан, шавар, эрдэст нуур зэрэг байгалийн ордын "усны нөөцийн менежментийн төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлдэг байх	
		8.5 Рашаан, шавар, эрдэст нуур зэрэг байгалийн ордын нөөцийг ашигласан үр дүнгийн судалгаатай, "усны экологи-эдийн засгийн үнэлгээ" "усны чанарын" үнэлгээг хийж усны чанарын стандартыг тогтоолгон ажилласан байх	
		8.6 Рашаан, шавар зэрэг байгалийн ордын горимын ажиглалтыг улирал бүр хийсэн байх	
		8.7 Рашааны ордын нөөц, геологийн тогтоцын онцлог байдалд нийцсэн онцгой болон энгийн хамгаалалтын бүс эрүүл ахуйн бүсийг тогтоон мөрдөн ажилласан байх	
9.	Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ	9.1 Үйлчлүүлэгчийг угтах, үдэн гаргах үйлчилгээг нэвтрүүлж, лавлагаа мэдээллийн хөтөч, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх	
		9.2 Ажлын цагийн хуваарь, үйлчлүүлэгчийн эрх, баримтлах зарчим болон бусад лавлагаа мэдээллийг ил тод байрлуулсан байх	
		9.3 Хүлээлгийн танхимд хүрэлцэхүйц суух сандал байрлуулсан байх	
10.	Сувилуулагчдыг хүлээн авах	10.1 Сувилуулагчдыг хүлээн авах журамтай байх	
		10.2 Сувилуулагчдыг сувилалд илгээх хуудсаар хүлээн авдаг байх	
		10.3 Сувилуулагчдыг хүлээн авч бүртгэх, үзлэгийн өрөө нь стандартын шаардлага хангасан байх	
11.	Яаралтай тусламж	11.1 Яаралтай тусламж үзүүлэх нэгжийг зохион байгуулсан, шаардагдах багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан байх	
		11.2 Амь тэнссэн үед амилуулах суурь тусламж үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх сургалтанд эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан байх	

12.	Үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө	12.1 Батлагдсан бүтцийн дагуу үзлэг, эмчилгээний өрөөнүүдийг зохион байгуулж, шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байх.	
		12.2 Үзлэг, эмчилгээний өрөөнүүдийн ачаалалыг зохицуулсан байх	
		12.3 Тусламж үйлчилгээний чиглэлийн дагуу эмчилгээ, сувилгаа үзүүлэх өвчний жагсаалтыг гаргаж, мөрддөг байх	
13.	Эмчилгээ, оношилгоо, технологи эзэмшилт	13.1 Оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж, стандартыг мөрддөг байх	
		13.2 Түгээмэл үйлдлийн технологийг эзэмшсэн байх	
14.	Эмийн эмчилгээний тасгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ	14.1 Шаардлагатай тохиолдолд эмчийн заалтаар эмийн эмчилгээ хийх өвчний жагсаалтыг гарган стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
		14.2 Мэргэжлийн эмчийн заалтын дагуу эмийг зохистой хэрэглэдэг байх	
		14.3 Эмийн эмчилгээ хийх өвчний жагсаалтын дагуу зайлшгүй шаардлагатай эмээр хангагдсан байх	
		14.4 Сувилуулагчийн эмгэг хүндэрч, сэдэрсэн тохиолдолд холбогдох байгууллагуудаас мэргэжлийн зөвлөгөө авч, шилжүүлдэг байх	
15.	Сувилахуйн тусламж үйлчилгээ	15.1 Сувилахуйн стандарт, удирдамж, тухайн сувиллын баталж гаргасан жагсаалтын дагуу сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлдэг, гарын авлагаар хангагдсан байх	
		15.2 Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлсэн байх.	
		15.3 Сувилахуйн тусламж үйлчилгээнд хяналт тавьж, үр дүнг тооцдог байх	
16.	Сэргээн засах тусламж үйлчилгээ	16.1 Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх технологи, нэр төрлийн жагсаалт гарган стандарт, удирдамжаар эмнэлгийн мэргэжилтнүүдийг хангасан байх	
		16.2 Батлагдсан жагсаалтын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах өрөө багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
		16.3 Сэргээн засах эмчилгээнд хамруулсан бүртгэлтэй, үр дүнг тооцсон судалгаатай байх	
17.	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	17.1 УАУ-ны оношийн ангилалын дагуу өвчний жагсаалт гарган батлагдсан стандарт, удирдамжийг мөрдөж ажилладаг байх	
		17.2 УАУ-ны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах өрөө, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
		17.3 Мэргэжлийн эмчийн заалтаар эмийн эмчилгээ хийсэн, бүртгэлтэй байх	

		17.4 УАУ-ны гардан үйлдлийн засал тус бүрийн өрөөтэй, засал бүрийг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
18.	Эмчилгээний хоолны үйлчилгээ	18.1 Үйлчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоолны цэс боловсруулж баталсан, хоолыг технологи, аргачлалын дагуу хийдэг байх	
		18.2 Эмчилгээний хоолны аюулгүй байдлыг хангаж, зохих журмын дагуу бэлтгэн хүргэдэг байх	
		18.3 Үйлчлүүлэгчдэд олгож байгаа хоолны илчлэг, орц, нормыг тооцож, хянадаг байх	
		18.4 Тасаг, нэгжид хэвтэн эмчлүүлэгчид хооллох тав тухтай орчин бүрдүүлсэн байх	
БҮЛЭГ 3.Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ			
19.	Барилга, байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага	19.1 Эрүүл ахуйн шаардлагын дагуу зөв зохион байгуулагдсан зориулалтын байртай, үйлчлүүлэгчийн болон үзлэг, эмчилгээний хэсэг нь тусдаа байх	
		19.2 Гадна талбай орчны стандартын шаардлага хангасан тохижилттой байх	
		19.3 Бүх өрөө байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулах системтэй байх	
		19.4 Өрөө бүрт хэвийн ажиллагаатай, ажилбарын өрөөнүүд мэдрэгчтэй болон тохой хөлөөр ажилладаг угаалтууртай байх	
		19.5 Нянгийн эсрэг шингэн саван, спиртэнд суурьтай халдваргүйжүүлэх бодис, гарын цаасан алчуураар хангасан байх	
20.	Халдвараас сэргийлэх үйл ажиллагаа	20.1 Халдварын сэргийлэлт, хяналт (ХСХ)-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг байх	
		20.2 Үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын журамтай, түүнийг эмнэлгийн ажилтнуудад танилцуулж мөрдөж ажилладаг байх	
		20.3 ХСХ-ын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг байгууллагын төсөв болон төсөл хөтөлбөрт оруулж шийдвэрлүүлдэг байх	
		20.4 ХСХ-ыг сайжруулах сайн туршлага, шинэ санааг нэвтрүүлж хэрэгжүүлдэг байх	
		20.5 Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг тогтсон хугацаанд хянаж, дүгнэдэг, үр дүн гарсан байх	
21	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, хариу арга хэмжээ	21.1 Тандалт хийж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын тандалтыг хийдэг байх	
		21.2 ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг зохих журмын дагуу мэдээлж, хариу арга хэмжээг цаг алдалгүй авдаг байх	

		21.3 Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудад тандалт хийж шалгуур хуудас хөтөлдөг байх	
22.	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах	22.1 Ажилтнуудыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа зохион байгуулалттайгаар хамруулж, эмчлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг байх	
		22.2 Ажилтнуудын амрах, бие бялдрыг чийрэгжүүлэх боломж нөхцлөөр хангасан байх	
		22.3 Шинээр ажилд орж буй иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байх	
		22.4 Халдвар авах эрсдэлд хүчин зүйлд өртөлтийг бүртгэж, халдвараас сэргийлэх арга хэмжээг авсан байх	
		22.5 Тасаг, нэгж бүр өртөлтийн дараах сэргийлэлтийн иж бүрдлээр хангагдсан байх	
		22.6 Эрүүл мэндийн ажилтныг дүрэмт болон хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, нөөцийг бүрдүүлсэн байх	
		22.7 Цусаар дамжих халдвартай эмнэлгийн ажилтны эрүүл мэндэд хяналт тавьж, ажил үүргээ гүйцэтгэх үед халдвар дамжуулах эрсдлээс сэргийлж заавар зөвлөмж өгдөг байх	
23.	Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгчгүйтгэл	23.1 Бохир, цэвэр, ариун хэсгээр тусгаарласан ариутгалын тасаг, хэсэгтэй, ариутгалын журамтай, түүнийг мөрддөг байх	
		23.2 Ариутгалын тоног төхөөрөмжөөр хангагдсан, баталгаажилт хийлгэсэн байх	
		23.3 Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьж, баталгаажуулдаг байх	
		23.4 Улсын бүртгэлд бүртгэгдсэн, зөвшөөрөл, дүгнэлттэй чанарын шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх	
		23.5 Ариутгалын үйл ажиллагаанд хөтлөгддөг анхан шатны маягтууд бүрэн хөтлөгдсөн байх	
		23. Ариун материалыг зөв хадгалж хэрэглэдэг байх	
		23.6 Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлдэг байх	
		23.7 Шавж, мэрэгч устгал хийлгэдэг байх	
24	Хог хаягдлын менежемент	24.1 Хог хаягдлыг зохих журмын дагуу ангилан ялгаж цуглуулдаг байх	
		24.2 Тээвэрлэх сав, тэргэнцэртэй, зөөвөрлөх маршрут, цагийг тогтоосон байх	
		24.3 Эрүүл ахуйн шаардлага хангасан түр хадгалах байртай, жин, тавиур зэрэг шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх	

		24.4 Устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх эсвэл байгаль орчинд халгүй аргаар, зохих журмын дагуу устгадаг байх	
		24.5 Хог хаягдлын таних тэмдэгтэй зориулалтын уут, саваар хангасан байх	
		24.6 Хог хаягдлын байдлыг сар бүр нэгтгэж дүгнээд мэдээлдэг байх	
25.	Угаалга, цэвэрлэгээ	25.1 Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байх	
		25.2 Ангилан ялгаж угаах тоног төхөөрөмж, тээвэрлэх уут, сав, хадгалах тавиур, шүүгээтэй байх	
		25.3 Халдваргүйжүүлэх, цагаан хэрэгсэл угаах зориулалтын бодисоор хангагдсан байх	
		25.4 Сувилалын орчныг эрсдлийн бүсээр ангилан, таних тэмдэгжүүлэн цэвэрлэгээний хуваарьтай, мөрдөж ажилладаг, хяналт тавьдаг байх	
		25.5 Цэвэрлэгээний материал бүхий тэргэнцэр, иж бүрдэлтэй, халдваргүйжүүлж хэрэглэдэг байх	
		25.6 Цэвэрлэгээний материалыг хадгалах цэгтэй байх	
26.	Тусгаарлан сэргийлэлт	26.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын 26.2 үед ажиллах төлөвлөгөө, бэлэн байдлыг хангасан байх	
		26.3 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед хэрэглэгдэх тусгаарлах өрөөтэй байх	
		26.4 Тусгаарлах өрөө нь хувцас, багаж материал, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан, нөөцтэй байх	
		26.5 Хамгаалах хувцас хэрэгслийг эрүүл мэндийн ажилтнууд зөв өмсөж, тайлж чаддаг байх	
		26.6 Тасаг дотор халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах нөхцлийг хангасан байх	
27.	Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага, халдварын эсрэг дэглэм	27.1 Эрүүл ахуйн шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэгтэй, зөв зохион байгуулагдсан гал тогоотой байх	
		27.2 Хоол бэлтгэх, үйлдвэрлэх, хөргөх, хоолны хэрэгслийг угааж, хатаах багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	
		27.3 Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд материал нь чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын дүгнэлттэй, баталгаажсан байх	
		27.4 Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангаж хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	

		27.5 Хоол үйлдвэрлэлийн хэсгийн ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээг хийлгэсэн байх	
		27.6 Хоолны дээж авч, хадгалалтын хугацааг мөрддөг, устгалын бүртгэлтэй байх	
28.	Үйлчлүүлэгчдэд зориулсан өвөрмөц шаардлага	28.1 Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоноглосон угаалтуур, суултууртай, байх	
		28.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан матрац, цагаан хэрэгслээр хангасан байх	
		28.3 Үйлчлүүлэгчдэд зориулсан угаалгын үйлчилгээ нэвтрүүлсэн байх	
29	Рашаан, усан эмчилгээний өрөөний эрүүл ахуйн нөхцөл	29.1 Рашаан, усан эмчилгээний өрөө нь агааржуулалтын системтэй, тусдаа болон тусгаарлагч кабинтай байх	
		29.2 Хувцас солих, рашаан, усан эмчилгээний дараа дулаан амрах нөхцлийг бүрдүүлсэн байх	
		29.3 Рашаан, усан эмчилгээний өрөө нь үйлчлүүлэгчид хальтирч унахааргүй дэвсгэр, шалавч, улавчтай, зааврын дагуу халдваргүйтгэж, угаадаг байх	
30.	Шавар эмчилгээний өрөөний эрүүл ахуйн нөхцөл	30.1 Шавар эмчилгээний өрөө нь тусдаа болон тусгаарлагч кабинтай байх	
		30.2 Шавар халаах, төлжүүлэх, хадгалах байртай байх	
		30.3 Шавар эмчилгээний үед болон дараа дулаанаа хадгалах нөхцөл бүрдүүлсэн байх	
		30.4 Шавар эмчилгээний дараа шавраа угаах уян шүршүүрийн кабин хүрэлцээтэй байх	
		30.5 Үйлчлүүлэгчдэд зориулсан улавчтай, уян шүршүүрийн кабин хальтирч унахааргүй дэвсгэр, шалавчаар хангагдсан, зааврын дагуу халдваргүйтгэж, угаадаг байх	
31.	Хөдөлгөөн засал эмчилгээний эрүүл ахуйн нөхцөл	31.1 Хөдөлгөөн засал эмчилгээний өрөө нь тусдаа, өрөөний талбай нь стандартанд заагдсан хэмжээг хангасан байх	
		31.2 Агааржуулах системтэй байх	
32.	Физик эмчилгээний хэсгийн эрүүл ахуйн нөхцөл	32.1 Физик эмчилгээний төрлөөр тусдаа өрөөтэй байх	
		32.2 Багаж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангасан байх газардуулгатай байх	
		32.3 Жийргэвчийг хадгалах, эмийн уусмалыг бэлтгэх тусгай өрөө, хатаах шүүгээтэй байх	
33.	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	33.1 Багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтын дэвтэр тогтмол хөтөлдөг байх	
		33.2 Шаардлагатай тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийгдсэн байх	

		33.3 Цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн ажиллагааг хангах талаар мэргэжлийн байгууллагуудтай гэрээтэй ажилладаг байх	
		33.4 Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгүүртэй байх	
34.	Галын аюулгүй ажиллагаа	34.1 Галын аюулгүй байдлын талаар ажилтнууд сургалтанд хамрагдсан байх	
		34.2 Галын байцаагчийн дүгнэлттэй байх	
		34.3 Галын үед яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай, дуудлагын болон арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын даргаар баталгаажуулсан байх	
		34.4 Гал унтраах техник, хэрэгслээр шаардлагатай өрөө, тасалгаа, цэгүүдийг бүрэн хангасан байх	
		34.5 Галын хорыг зохих журмын дагуу байрлуулж, тус бүрт нь техник ашиглалтын паспорт хөтөлсөн, ашигласан болон цэнэглэсэн бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн, мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн байх	

Б. Улирлын үйл ажиллагаатай сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүд

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	
			Байгууллага	Шинжээч
БҮЛЭГ 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт				
1.	Байгууллагын удирдлага, манлайлал	1.1 Бүтэц зохион байгуулалт нь тусгай зөвшөөрөлд заагдсан үйлчилгээний чиглэлээр зохион байгуулагдсан байх		
		13.2 Эрүүл мэндийн ажилтнууд стандартад заагдсан орон тоогоор бүрэн ажилладаг байх		
		13.3 Эрүүл мэндийн байгууллага нь шаардлагатай стандарт, удирдамж, эрх зүйн баримт бичгээр эрүүл мэндийн ажилтнуудыг хангасан байх		
		13.4 Байгууллага нь стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй байх		
		13.5 Санхүүгийн хяналт, шалгалтад хамрагдсан,зөрчилгүй ажилласан байх		
		13.6 Ажлын байрны тодорхойлолтыг ажилтан бүрээр гарган баталгаажуулж, ажилтнуудыг байршуулсан байх.		
		13.7 Статистик, бүртгэл мэдээллийг журмын дагуу тайлагнадаг байх		
2.	Хүний нөөцийн хөгжил	2.1 Эмнэлгийн мэргэжилтнүүд нь бүгд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх		
		2.2 Хүний нөөцийг чадавхижуулах сургалт Жил бүр тусгай хөтөлбөрөөр зохион байгуулдаг байх		

3	Тусламж үйлчилгээний чанарын удирдлага	3.1	Чанарын алба, баг ажиллаж, чанарын үзүүлэлтийн жагсаалтыг гарган мөрдүүлсэн байх	
		3.2	Чанар сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулдаг байх	
		3.1	Байгууллага нь ажилтан бүрээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.2	Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.3	Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх	
4.	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлага	4.1	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын багтай, төлөвлөгөөтэй ажилладаг байх	
		4.2	Байгууллага нь аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг тогтмол хийдэг байх	
		4.3	Эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьдаг байх	
5.	Байгууллагын соёл	5.1	Байгууллагын соёлыг төлөвшүүлсэн байх	
		5.2	Урлаг, соёлын арга хэмжээ явуулах нөхцөл хангагдсан байх	
БҮЛЭГ 2. Тусламж, үйлчилгээний технологийн мөрдөлт				
6.	Сувилуулагчдыг хүлээн авах болон яаралтай тусламж үйлчилгээ	6.1	Сувилуулагчдыг хүлээн авах журамтай, мөрддөг байх	
		6.2	Сувилуулагчдыг сувилалд илгээх бичгээр хүлээн авдаг байх	
		6.3	Сувилуулагчдыг хүлээн авч бүртгэл, үзлэг хийх, тусламж үзүүлэх өрөө нь стандартын шаардлага хангасан байх	
		6.4	Хүлээн авах өрөөнд яаралтай тусламж үзүүлэхэд шаардагдах эмүүдтэй байх	
		6.5	Яаралтай тусламжийн багаж хэрэгслээр хангагдсан байх	
7.	Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ	7.1	Үйлчлүүлэгчийг угтах, үдэн гаргах үйлчилгээг нэвтрүүлж, лавлагаа мэдээллийн хөтөч, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх	
		7.2	Ажлын цагийн хуваарь, үйлчлүүлэгчийн эрх, баримтлах зарчим болон бусад лавлагаа мэдээллийг ил тод байрлуулсан байх	
8.	Байгалийн нөөцийн ашиглалт	8.1	Рашааны ордыг ашиглах зөвшөөрөлтэй байх	
		8.2	Рашааныг ашиглах гэрээтэй байх	
		8.3	Рашаан, шавар, "усны нөөцийн менежментийн төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлдэг байх	
		8.4	Рашаан, шавар, зэрэг байгалийн ордын нөөцийг ашигласан үр дүнгийн судалгаатай, усны экологи-эдийн засгийн үнэлгээ" "усны чанарын" үнэлгээг хийж усны чанарын стандартыг тогтоолгон ажилласан байх	

		8.5	Рашаан, шавар зэрэг байгалийн ордын горимын ажиглалтыг улирал бүр хийсэн байх	
		8.6	Рашааны ордын нөөц, геологийн тогтоцын онцлог байдалд нийцсэн онцгой болон энгийн хамгаалалтын бүс эрүүл ахуйн бүсийг тогтоон мөрдөн ажилласан байх	
9.	Үзлэг, оношилгоо, эмчилгээ зөвлөгөө	9.1	Батлагдсан бүтцийн дагуу үзлэгийн болон эмчилгээний өрөөнүүдийг зохион байгуулж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байх	
		9.2	Үзлэг, эмчилгээний өрөөнүүдийн ачаалалыг зохицуулсан байх	
10.	Эмчилгээ, оношилгоо, технологи эзэмшилт	10.1	Эмнэлгийн мэргэжилтнүүд оношилгоо, эмчилгээ эмнэлзүйн удирдамж, стандартыг мөрддөг байх	
		10.2	Түгээмэл үйлдлийн технологийг эзэмшсэн байх	
11.	Ажилбар, тарианы. өрөөний үйл ажиллагаа	11.1	Ажилбар, тарианы зориулалтын өрөөтэй, эм тариа, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангасан байх	
		11.2 11.3	Ажилбар, тариаг технологийн аргачлалын дагуу хийдэг, гарын авлагаар хангасан байх	
		11.4	Ажилбар, тарианы технологийн мөрдөлтөд графикийн дагуу хяналт, үнэлгээ хийдэг байх	
12.	Сувилахуйн тусламж үйлчилгээ	12.1	Сувилахуйн тусламж үйлчилгээний эмнэлэгт мөрдөн ажиллах стандарт, удирдамжийн жагсаалт гаргасан, сувилагч нарыг гарын авлагаар хангасан байх	
		12.2	Сувилахуйн тусламж үйлчилгээнд хяналт тавьж, үр дүнг тооцдог байх	
13.	Сэргээн засах тусламж үйлчилгээ	13.1	Сэргээн засах тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийг мөрддөг байх	
		13.2	Сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт, технологитой, түүнийг бүрэн хэрэгжүүлсэн байх	
		13.3	Сувилуулагчдын сэргээн засах эмчилгээндхамруулсан бүртгэлтэй, үр дүнгийн судалгаатай байх	
		13.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах, сувилуулах нөхцлийг бүрдүүлсэн байх	
14.	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	14.1	УАУ-ны оношийн ангилалын дагуу өвчний жагсаалт гарган батлагдсан стандарт, удирдамжийг мөрдөж ажилладаг байх	
		14.2	УАУ-ны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах өрөө, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	

15.	Эмчилгээний хоолны үйлчилгээ	15.1 Үйлчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоолны цэс боловсруулж баталсан, хоолыг технологи, аргачлалын дагуу хийдэг байх	
		15.2 Сувилуулагчид хооллох тав тухтай орчин бүрдүүлсэн байх	
БҮЛЭГ 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ			
16.	Барилга, байгууламж (гэр)-ын , орчны эрүүл ахуйн шаардлага	16.1 Эрүүл ахуйн шаардлагын дагуу зөв зохион байгуулагдсан зориулалтын байртай, үйлчлүүлэгчийн болон үзлэг, эмчилгээний хэсэг нь тусдаа байх	
		16.2 Гадна талбай орчны стандартын шаардлага хангасан тохижилттой байх	
		16.3 Бүх өрөө байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулах системтэй байх	
		16.4 Өрөө бүрт хэвийн ажиллагаатай, ажилбарын өрөөнүүд мэдрэгчтэй болон тохой хөлөөр ажилладаг угаалтууртай байх	
		16.5 Нянгийн эсрэг шингэн саван, спиртэнд суурьтай халдваргүйжүүлэх бодис, гарын цаасан алчуураар хангасан байх	
17.	Халдвараас сэргийлэх үйл ажиллагаа	17.1 Халдварын сэргийлэлт, хяналт (ХСХ)-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг байх	
		17.2 Үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын журамтай, түүнийг эмнэлгийн ажилтнуудад танилцуулж мөрдөж ажилладаг байх	
		17.3 ХСХ-ын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг байгууллагын төсөв болон төсөл хөтөлбөрт оруулж шийдвэрлүүлдэг байх	
		17.4 ХСХ-ыг сайжруулах сайн туршлага, шинэ санааг нэвтрүүлж хэрэгжүүлдэг байх	
		17.5 Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг тогтсон хугацаанд хянаж, дүгнэдэг, үр дүн гарсан байх	
18.	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, хариу арга хэмжээ	18.1 Тандалт хийж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)- ын тандалтыг хийдэг байх	
		18.2 ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг зохих журмын дагуу мэдээлж, хариу арга хэмжээг цаг алдалгүй авдаг байх	
		18.3 Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудад тандалт хийж шалгуур хуудас хөтөлдөг байх	
19.	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах	19.1 Ажилтнуудыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа зохион байгуулалттайгаар хамруулж, эмчлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг байх	

		19.2 Ажилтнуудын амрах, бие бялдрыг чийрэгжүүлэх боломж нөхцлөөр хангасан байх	
		19.3 Шинээр ажилд орж буй иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байх	
		19.4 Халдвар авах эрсдэлд хүчин зүйлд өртөлтийг бүртгэж, халдвараас сэргийлэх арга хэмжээг авсан байх	
		19.5 Тасаг, нэгж бүр өртөлтийн дараах сэргийлэлтийн иж бүрдлээр хангагдсан байх	
		19.6 Эрүүл мэндийн ажилтныг дүрэмт болон хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, нөөцийг бүрдүүлсэн байх	
		19.7 Цусаар дамжих халдвартай эмнэлгийн ажилтны эрүүл мэндэд хяналт тавьж, ажил үүргээ гүйцэтгэх үед халдвар дамжуулах эрсдлээс сэргийлж заавар зөвлөмж өгдөг байх	
20.	Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгчгүйтгэл	20.1 Бохир, цэвэр, ариун хэсгээр тусгаарласан ариутгалын тасаг, хэсэгтэй, ариутгалын журамтай, түүнийг мөрддөг байх	
		20.2 Ариутгалын тоног төхөөрөмжөөр хангагдсан, баталгаажилт хийлгэсэн байх	
		20.3 Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьж, баталгаажуулдаг байх	
		20.4 Улсын бүртгэлд бүртгэгдсэн, зөвшөөрөл, дүгнэлттэй чанарын шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх	
		20.5 Ариутгалын үйл ажиллагаанд хөтлөгддөг анхан шатны маягтууд бүрэн хөтлөгдсөн байх	
		20.6 Ариун материалыг зөвхадгалж хэрэглэдэг байх	
		20.7 Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлдэг байх	
		20.8 Шавж, мэрэгч устгал хийлгэдэг байх	
21.	Хог хаягдлын менежемент	21.1 Хог хаягдлыг зохих журмын дагуу ангилан 21.2 ялгаж цуглуулдаг байх	
		21.3 Тээвэрлэх сав, тэргэнцэртэй, зөөвөрлөх маршрут, цагийг тогтоосон байх	
		21.4 Эрүүл ахуйн шаардлага хангасан түр хадгалах байртай, жин, тавиур зэрэг шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх	
		21.5 Устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх эсвэл байгаль орчинд халгүй аргаар, зохих журмын дагуу устгадаг байх	
		21.6 Хог хаягдлын таних тэмдэгтэй зориулалтын уут, саваар хангасан байх	

		21.7 Хог хаягдлын байдлыг сар бүр нэгтгэж дүгнээд мэдээлдэг байх	
22.	Угаалга, цэвэрлэгээ	22.1 Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байх	
		22.2 Ангилан ялгаж угаах тоног төхөөрөмж, тээвэрлэх уут, сав, хадгалах тавиур, шүүгээтэй байх	
		22.3 Халдваргүйжүүлэх, цагаан хэрэгсэл угаах зориулалтын бодисоор хангагдсан байх	
		22.4 Сувилалын орчныг эрсдлийн бүсээр ангилан, таних тэмдэгжүүлэн цэвэрлэгээний хуваарьтай, мөрдөж ажилладаг, хяналт тавьдаг байх	
		22.5 Цэвэрлэгээний материал бүхий тэргэнцэр, иж бүрдэлтэй, халдваргүйжүүлж хэрэглэдэг байх	
		22.6 Цэвэрлэгээний материалыг хадгалах цэгтэй байх	
23.	Тусгаарлан сэргийлэлт	23.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын 23.2 үед ажиллах төлөвлөгөө, бэлэн байдлыг 23.3 хангасан байх	
		23.4 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед хэрэглэгдэх тусгаарлах өрөөтэй байх	
		23.5 Тусгаарлах өрөө нь хувцас, багаж материал, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан, нөөцтэй байх	
		23.6 Хамгаалах хувцас хэрэгслийг эрүүл мэндийн ажилтнууд зөв өмсөж, тайлж чаддаг байх	
		23.7 Тасаг дотор халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах нөхцлийг хангасан байх	
24.	Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага, халдварын эсрэг дэглэм	24.1 Эрүүл ахуйн шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэгтэй, зөв зохион байгуулагдсан гал тогоотой байх	
		24.2 Хоол бэлтгэх, үйлдвэрлэх, хөргөх, хоолны хэрэгслийг угааж, хатаах багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	
		24.3 Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд материал нь чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын дүгнэлттэй, баталгаажсан байх	
		24.4 Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангаж хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	
		24.5 Гал тогооны ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээг хийлгэсэн байх	
		24.6 Хоолны дээж авч, хадгалалтын хугацааг мөрддөг, устгалын бүртгэлтэй байх	
25.	Үйлчлүүлэгчдэд зориулсан өвөрмөц шаардлага	25.1 Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоноглосон угаалтуур, суултууртай байх	

		25.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан матрац, цагаан хэрэгслээр хангасан байх	
		25.3 Үйлчлүүлэгчдэд зориулсан угаалгын үйлчилгээ нэвтрүүлсэн байх	
26.	Рашаан, усан эмчилгээний өрөөний эрүүл ахуйн нөхцөл	26.1 Рашаан, усан эмчилгээний өрөө нь агааржуулалтын системтэй, тусдаа болон тусгаарлагч кабинтай байх	
		26.2 Хувцас солих, рашаан, усан эмчилгээний дараа дулаан амрах нөхцлийг бүрдүүлсэн байх	
		26.3 Рашаан, усан эмчилгээний өрөө нь үйлчлүүлэгчид хальтирч унахааргүй дэвсгэр, шалавч, улавчтай, зааврын дагуу халдваргүйтгэж, угаадаг байх	
27.	Шавар эмчилгээний өрөөний эрүүл ахуйн нөхцөл	27.1 Шавар эмчилгээний өрөө нь тусдаа болон тусгаарлагч кабинтай байх	
		27.2 Шавар халаах, төлжүүлэх, хадгалах байртай байх	
		27.3 Шавар эмчилгээний үед болон дараа дулаанаа хадгалах нөхцөл бүрдүүлсэн байх	
		27.4 Шавар эмчилгээний дараа шавраа угаах уян шүршүүрийн кабин хүрэлцээтэй байх	
		27.5 ҮҮйлчлүүлэгчдэд зориулсан улавчтай, уян шүршүүрийн кабин хальтирч унахааргүй дэвсгэр, шалавчаар хангагдсан, зааврын дагуу халдваргүйтгэж, угаадаг байх	
28.	Хөдөлгөөн засал эмчилгээний эрүүл ахуйн нөхцөл	28.1 Хөдөлгөөн засал эмчилгээний өрөө нь тусдаа, өрөөний талбай нь стандартанд заагдсан хэмжээг хангасан байх	
		28.2 Агааржуулах системтэй байх	
29.	Физик эмчилгээний хэсгийн эрүүл ахуйн нөхцөл	29.1 Физик эмчилгээний төрлөөр тусдаа өрөөтэй байх	
		29.2 Багаж, тоног төрхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангасан байх газардуулгатай байх	
		29.3 Жийргэвчийг хадгалах, эмийн уусмалыг бэлтгэх тусгай өрөө, хатаах шүүгээтэй байх	
30.	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	30.1 Багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтын дэвтэр тогтмол хөтөлдөг байх	
		30.2 Шаардлагатай тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийгдсэн байх	
		30.3 Цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн ажиллагааг хангах талаар мэргэжлийн байгууллагуудтай гэрээтэй ажилладаг байх	
		30.4 Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгүүртэй байх	
31.	Галын аюулгүй ажиллагаа	31.1 Галын аюулгүй байдлын талаар ажилтнууд сургалтанд хамрагдсан байх	
		31.2 Галын байцаагчийн дүгнэлттэй байх	

		31.3 Галын үед яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай, дуудлагын болон арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын даргаар баталгаажуулсан байх	
		31.2 Гал унтраах техник, хэрэгслээр шаардлагатай өрөө, тасалгаа, цэгүүдийг бүрэн хангасан байх	
		31.3 Галын хорыг зохих журмын дагуу байрлуулж, тус бүрт нь техник ашиглалтын паспорт хөтөлсөн, ашигласан болон цэнэглэсэн бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн, мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн байх	

Үнэлгээ:

Шалгуур үзүүлэлтийг 10, 50, 0 оноогоор үнэлнэ.

- Үзүүлэлт бүрийг хангасан бол тус бүрд 100 оноо өгөх ба онооны нийлбэрээр үнэлнэ.
- Үзүүлэлтийг бүрэн хангаагүй бол 50 оноогоор үнэлнэ.
- Үзүүлэлтийг хангаагүй бол 0 оноогоор үнэлнэ.